



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/583

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн 2024 оны төсөв тодотгон батлах тухай" 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Жинст баг Хөгжил хорооллын халаалтын төв шугамын засвар шинэчлэлийн ажил, айл өрхүүдэд 50,000,000 (тавин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээг гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх эрхийг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д шилжүүлсүгэй.

2.Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ